



Ганжуур Данжуур их хөлгөн судрын зарим үгийн орчуулгын тухайд (Төвд-Монгол орчуулга)

Д.Гэрэлмаа*

Оршил

Ганжуур Данжуур нь Бурхан Шагжамүни буюу Бурхан багш ба түүний шашны гүн гүнзгий үзэл баримтлал онолыг маш их цэгц, зохион байгуулалтай эмхэтгэж бүтээсэн нэвтэрхий толь билээ. Ганжуур Данжуур нь шашны ном хэмээх тодотголтой боловч үндсэндээ дорно дахины 5000 жилийн хугацааны эрдэм соёл, сэтгэл судлал тэргүүтэн шинжлэх ухааныг багтаасан агуу их бүтээл юм.

Ганжуур нь Энэтхэгийн их сэтгэгч гэгээрсэн Будда буюу Бурхан багшийн айлдсан сургаалын эмхэтгэл 113 ботид хуваагдсан шинжлэх ухааны онол баримтлалын их бүтээл юм. Цахарын Лигдэн хутагт хааны үед (1603-1634) бүрэн орчуулсан. Монгол үсгийн Ганжуурыг Энх-Амгалан хааны үед (1662-1722) ахин шүүж ариутгаад, 1717-1720 оны хооронд бард гаргажээ. Данжуур нь Бурхан Буддагаас хойш 500-аад жилийн хугацаанд Энэтхэгт мэндэлсэн эрдэмтэн шинжлэгчид Бурхан буддын сургаалуудыг онол суурь баримтлал болгон түүнийгээ өөрсдийн оюун бодлоор тайлбарлан баяжуулж эмхтгэсэн 226 боть их нэвтэрхий толь юм. Манжийн Тэнгэрийг тэтгэгч хааны үед буюу 1742-1749 оны хооронд Данжуурыг монгол хэлэнд орчуулж хэвлэх ажлыг бүрэн хийж дуусчээ.

Дээрх хугацаанд Ганжуур, Данжуурыг бүрэн орчуулж дууссан боловч эрт үеэс монгол хэлэнд орчуулж байсан гэдэг нь зарим үг хэллэгээс нь илт ажиглагддаг. Мөн эл судрыг орчуулахдаа бүрэн төвд эхэд шүтэлгүй, самгард эхтэй нь тулгаж байсан нь орчуулгын үг хэллэг болон төгсгөлийн үг, зарим төвд эхэд байдаггүй зохиолуудаас харагддаг. Ганжуур, Данжуур судрыг монгол бичгээс кирил бичигт буулгах ажил явагдаж байгаа бөгөөд төвд эхтэй нь тулган буулгахад Ганжуурыг барлах явцад гарсан байж болзошгүй алдаа, хуудас хаягдсан, урд хойноо орсон, үг хаягдсан, буруу үгээр орчуулсан гэх мэт алдаа их байдаг. Харин Данжуурт эдгээр алдаа харьцангуй бага бөгөөд олон дахин шүүгдэж засагдаж орчуулагдсан байна.

Эх хэрэглэгдэхүүн: Монгол шунхан барын Ганжуур Данжуур, дэргэ, нартан барын төвд эх

*"Цогт цагийн хүрдэн" соёлын төв, эх бичиг судлаач

Зорилго: Тус илтгэлд зарим хуучирсан үг хэллэгийн утгыг төвд эх болон хам сэдвээс нь сэргээх, зарим үгсийн уг гарвалыг мөрдөж зөв дуудлагыг сэргээх, мөн зарим сонирхолтой орчуулгын жишээ авч тайлбарлахыг хичээлээ.

Түлхүүр үг: Хуучирсан үг хэллэг, харь үгээр орчуулсан жишээ, нэг үгийг олон үгээр орчуулсан жишээ

Үгсийн тайлбар, судалгаа

1.1 Утга нь тодорхойгүй хуучирсан үг хэллэгийг төвд эх болон хам сэдвээс нь сэргээх

Биеэл

Мо: beyeli **Тө:** spun **Утга:** ах дүү

Хам сэдэв: ...тэр мэтийн дохиог мэдвээс **биеэл** хийгээд охин дүүд магад болой хэмээх охины утга болой. **Биеэл** хэмээх нь ганц тангарагт эрэгтэй болой. Охин дүү хэмээх нь ганц тангарагт хатагтай болой... Данжуур22 (wa боть); “Дохиог магад баригч”, 522б

Энэ үг нь энэ ботид хоёр тохиолдсон бөгөөд бусад ботиудад “aq-a degüi” хэмээн орчуулсан байна. Үүнээс үзвэл төрсөн ах дүүг **биеэл** гэж хэлдэг байжээ. Үеэл (üyeli) хоёрдугаар үеийн, хаяал (qayali) бол гутгаар үеийн төрлийг хэлэх бөгөөд үүнээс үзвэл нэгдүгээр үеийн төрлийг биеэл гэдгийг дээрхээс харж болох юм. Мөн энэ үг толь бичгүүдэд байхгүй тул нутгийн аялгууны үг байж магадгүй гэж бодсон боловч зохиолын төгсгөлийн үгэнд “Булингар үгүй ёогийн үндэсний хааны бэрх тайлбар үүнийг шашныг мандуулагч Жавзандамбын номын хүрээний шавь гүүш даа лам номч нансо гэлэн Дагвабалдан монголчлон орчуулав” гэсэн байгаа нь энэ үгийг нутгийн аялгууны үг гэж хэлэхэд хэцүү байна. Учир нь Жавзандамбын номын хүрээ гэдэг нь үе үеийн Богд гэгээнтнүүд заларч байсан Нийслэл хүрээ буюу халх нутаг юм.

1.2 Ховор тохиолдсон зарим хуучин үг хэллэг

Гагай

Мо: γayai **Тө:** ne ne **Утга:** авга эгч

Хам сэдэв: ...тиймийн тул хоёр шинжлэлтийн тавдугаар бүлгээс, Эх хийгээд охин эгч ба ач охин бэргэн эмэг эх ба хадам эх хийгээд өөрийн **гагай** эгч ба ухаант эх наймд алдаршсаныг... Данжуур 20 (tsha боть); “Цогт Хэ очирын бэрх тайлбар очирын үгсийг түүсэн хэмээгдэх”, 9а

Энэ зохиолын төгсгөлийн үгэнд “Монголын хэлэнд орчуулагч Ар Хорчины ноён хутагт Агваандамба яринпил болой.” Тус үг уугуул монгол үг бөгөөд өвөрлөгч аялгуунд өргөн хэрэглэгддэг байна. Монгол хэлний товч тайлбар тольд “эцгийн эгч, охин дүү нар, гагай эгч (авга эгч)” гэж тайлбарласан байна.

2. санскрит, пали үгээр орчуулсан жишээ

Аглаг, араняатан

Аглаг, цөл, *мо:* aɣlaɣ, *тө:* dgon pa, dben

Аранятан, *мо:* aɣanyatan, *тө:* dgon pa, *са:* aara Nya, *Утга:* аглаг цөл, хол газар

...Тийн бөгөөд **аглаг** ба дуранд зохист, ой хийгээд **араняатан** ч... Ганжуур 6; (cha боть) 40a

Төвд хэлний dben эзгүй буйд газар, dgon pa нь лам нарын орших аглаг буйд газар бөгөөд Ганжуурын 5-р ботид dben-ыг цөл, dgon pa-г аглаг гэж орчуулсан бол 6-р ботид dben-г аглаг, dgon pa-г араняатан хэмээн орчуулсан байна. Тайлбар: Са: aaraNya, аглаг цөл, хол газар

Ганжуур Данжуур судрыг монголчууд төвд хэлнээс орчуулсан боловч зарим оноосон нэр, утга ялгах үгсийг санскрит, пали үгээр орчуулсан байна. Үүнээс монгол ганжуур, данжуурыг санскрит эхтэй нь тулгаж орчуулж байсныг харж болно.

Тиуаши

Шавь, *мо:* sabi, *тө:* slob ma

Тиуаши, *мо:* tiuasi, Пали: antevāsī, *Бенгал:* antebāsī, *Хятад:* di zi, *Япон:* dishi МГО: Tiusi *Утга:* шавь

“Древнетюркский словарь” номд энэ үгийг tetsä, tetsi хэмээн галигласан байдгаас эрдэмтэд тидши гэж уншиж байна. Монголчууд бурханы шашны санскрит гаралтай үг хэллэгийг түрэгээс авсан байх боломжгүй юм. Учир нь бурханы шашин хоёр удаа түрэгээр, төвдөөр дамжиж монгол оронд дэлгэрсэн гэдэг боловч ганжуур, данжуурыг орчуулах явцдаа самгард эхтэй нь тулгасан нь гарцаагүй юм. Мэргэд гарахын орон даягт энэ үг tiusi хэлбэрээр тохиолдох бөгөөд үүнээс улмаалж хайвал пали толь бичигт antevāsī хэлбэртэй байхыг үзээд тиуаши гэж унших нь зөв гэж дүгнэлээ.

Төвд хэлний slob ma хэмээх үгийг Ганжуур Данжуурын тарнийн ёсны нууцын, гүн агуу их номлолын буюу шавь оролцсон зан үйлийн хэсэгт **тиуаши**, бус үед **шавь** хэмээн орчуулж утгын ялгааг гаргасан байна.

3.1 Нэг үгийг олон үгээр орчуулах

Төвд хэлний tha mal pa, phal ba буюу эгэл жирийн гэсэн утгатай үгсийг Ганжуур, Данжуурт олон үгээр орчуулсан байна.

Энх *мо:* engke

Хам сэдэв:...Үзэл хэмээх нь **энхийн** дүрсийг тэвчиж адистидлах хэмээхийн утга болой... Данжуур22 (wa боть); “Найман үхээрийг номлогдохуй”, 525a; (Тайлбар: tha mal ba

гэсэн үгийг энх хэмээн орчуулсан нь нэг удаа тохиолдсон бөгөөд алдсан уу, эсвэл утгачилж орчуулсан уу гэдгийг хэлэхэд бэрх юм. Утгачилж орчуулсан бол нийт олон гэсэн утгаар орсон бололтой)

Элүүр мо: elegür

Хам сэдэв:...Ха үсэг таван рашаан тэргүүтнээс сэтгэхээр түүний **элүүрийн** өнгийг булаамуй... Данжуур21 (dza боть); “Цогт үнэхээр барилдуулах дандар, гучин дөтгөөр идээмэл”, 475а; (Тайлбар: энэ үг мөн монгол данжуурт нэг удаа тохиолдох бөгөөд толь бичигт ч байхгүй тул утгыг нь тодруулж бататгахад бэрхтэй юм.)

Исэл мо: isle/isl-e

Хам сэдэв:...Тэд ерийн бэлгэ чанар буй хэмээх нь үхэхийн цаг тэргүүтэн урьд үзүүлсэн тэд егүзэрс ба **исэл** эгэл бэртэгчнүүдийн нийтийн болой. Данжуур10 (ta боть); “Дандарын их хаан цогт Базардага-ын тийн номлолоос, хорин дөрөвдүгээр бүлгийн тийн номлол”, 238а; (Тайлбар: зүгээр, сул)

Дүр мо: düri

Хам сэдэв:...Ёгини охин тэнгэр онохуйяа бус бөгөөс **дүрийн** тарничин ард юун өгүүлтэл... Ганжуур4 (nga боть); “Будда гавал нэрт тэнсэл үгүй ёгинийн дандар нууц ч маш нууцын мандал хийгээд Хэрүга үүсгэх бясалгалын долоодугаар бүлэг болой”, 201б; (Тайлбар: Хэв шинж байдал, овор дүр. Дүрийн хүмүүн гэж Монголын нууц товчоонд дөрвөн удаа тохиолддог. Нэг тохиолдолд нь “үт дүрийн хүмүүн” гэж гардаг. Энэ талаар дэлгэрэнгүй судалгааг Ш.Чоймаа багш хийсэн байдаг)

Үт мо: ütü/etü

Хам сэдэв: Тийн атал үт доорд авьяасаар хэмээгдэх тэргүүтэнд ... Данжуур18 (tsa боть); “Хэ очирын дандар, Би үгүй эхийг бэлгэдсэн”, 269б; (Тайлбар: эгэл сул зүгээр гэсэн утгтай “үтэл” хэмээх үгтэй язгуур нэг байж болох юм.)

Үтэл мо: ütele

Хам сэдэв:...Зарим нэгэн энэ дохиог үтэл эхнэрүүдийн мөн бөгөөд түүний цагт сайтар хэмээх нь... Данжуур10 (ta боть); “Үндсийн дандарын хаан цогт Базардага хэмээхийн тийн номлол”, 9а; (Тайлбар: Энгийн, эгэл, сул, зүгээр)

3.2 Орчуулга бол аль болох зөв утгыг нь оноож тавихыг шаарддаг амаргүй ажил билээ. Хатуужил сахин хоол унд идэлгүй хамаг амьтны зовлонг энэ биедээ эдлэн амьтны тусын тулд бясалгадаг хуврагийн нэгэн санваарыг монголчууд ихэвчлэн нүгнээ гэдэг бөгөөд харин энэ үгийг ганжуур данжуурт төвд эхээр үгчлэн орчуулах буюу **чилэн аху**, эсвэл зан үйлээр нь **өлмөрөн** хэмээн орчуулжээ. Энэ мэт уран тансгаар орчуулсан, сонирхол татам жишээ маш олон байна.

13-14-р зууны буюу дундад үеийн монгол хэлний сурвалж бичгийн зарим үгсийг ганжуур, данжуураас тодруулах боломжтой. Учир нь ганжуур данжуур нь хэмжээний хувьд их учир аливаа үг олон давтагддаг, мөн төвд эхээс утгыг нь бүрэн мэдэж болох юм.

1. Бүрнээ Д, Энхтөр Д, Уламжлалт монгол орчуулгын судлалд, УБ., 2003;
2. Бүрнээ Д, ЭнхтөрД, Төвд Монгол толь, УБ., 2006;
3. Мэргэд гарахын орон, Бээжин, 1988;
4. Олон улсын монголч эрдэмтдийн Х их хурлын илтгэлүүд, II боть, монгол хэл соёлын тулгамдсан асуудлууд, УБ, 2012
5. Хүрэлбаатар Л, Судар шастирын билиг, УБ., 2002;
6. Цогт цагийн хүрдэн СТ, Монгол Ганжуур, (кирилжин монгол хөрвүүлэг), Том 4, 6, 2011, 2012, 2013
7. Цогт цагийн хүрдэн СТ, Монгол Данжуур, (кирилжин монгол хөрвүүлэг), Том 10,13, 18, 20, 21, 22, УБ., 2011, 2012, 2013;
8. Цэвэл Я, Монгол хэлний товч тайлбар толь, УБ, 1966;
9. Цэрэнсодном Д, Монголын бурханы шашны уран зохиол, УБ, 1997;
10. РерихЮ.Н., Тибетско-Русский-Английский словарь с санскритскими параллелями, Выпуск 1-10, Под общей редакцией Ю.Парфионовича и В.Дылыковой, Москва, 1983-1987;
11. Древнетюркский словарь, Ленинград, 1969;
12. འགྲུ་བ་ཡི་རྩོམ་སྒྲིག་པ་ལྟན་འགྲུ་ཤིང་། རྒྱ་རྒྱལ་གྱི་དཔེ་སྟླ་ལྷན་ཁག་གི་ཞུ་བ་ལྟར་། ཨ་ཕྱི་ཀློང་གི་ཡུལ་ནས་༡༩༥༤
13. <http://dictionary.tamilcube.com/http://dict.num.edu.mn/>
14. Ш. Чоймаа нар, Монгол хэлний хэл зүйн толь бичиг, I, II,УБ.,2005, 2006;

хавсралт

Ганжуур Данжуурын орчуулга	төвд эх	монгол бичиг	тайлбар	боть/хуудас
биеэл	spun	beyeli	ах дүү	Д 22; 522б
гагай	ne ne	γaγai	авга эгч	Д 20; 9а
Аглаг, цөл	dgon pa, dben	aγlay	аглаг	Г 6; 40а
Аранятан		aranyatan		Г 6; 40а
шавь	slob ma	sabi	шавь сурагч	
тиуаши		tiuasi		
эгэл	tha mal pa phal ba	egel	эгэл, ерийн	Д 10; 86а
энх		engke		Д 22; 525а
элүүр		elegür		Д 21; 475а
исэл		isle/isl-e		Д 10; 238а
дүр		düri		Г 4; 201б
үт		ütü/etü		Д 18; 269б
үтэл		ütele		Д 10; 9а
чилэн аху	bsnyang bar gnas	čilen aqu		Д 21; 288б
өлмөрөн		ölmeren		Д63; 53а